**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 18 өдөр Дугаар 14 Номгон

"Иргэний зөвлөл"-ийн гишүүн сонгон
шалгаруулах комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалаар батлагдсан "Иргэний зөвлөлийн дүрэм"-ийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд ажиллах "Иргэний зөвлөл"-ийн гишүүдийг сонгон шалгаруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: С.Үнэнбуян-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Гишүүдэд: Ц.Мөнхзул-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн ХурлынТэргүүлэгчдийн ажлын албаны Зохион байгуулалтын хэлтсийн дарга

Д.Уранчимэг-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Оюутболд-Цагдаагийн газрын дарга

Ж.Ариунаа-Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл

2. "Иргэний зөвлөл"-ийн дүрэмд заасны дагуу гишүүдийг сонгон шалгаруулж ажиллахыг комиссын дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 39 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

016182